БАТЛАВ
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА М.БАДАМСҮРЭН

**“ХҮНСНИЙ НОГОО” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД СУМ, БАГТ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГООР НОГООЧДОД НИЙЛҮҮЛЭХ ХҮЛЭМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2020.02.17 Чойбалсан хот

**1. Байршил** : Баянтүмэн сум, Хэрлэн сумын 5 дугаар баг
**2. Нийлүүлэх барааны хэмжээ** : 4*8 м²-ийн хэмжээтэй /32м²/ зуны нийлэг хальсан бүрхүүлтэй MNS 6636:2016 стандартын шаардлага хангасан иж бүрэн 30 хүлэмжийг /Дорнод аймгийн Баянтүмэн суманд 15, Хэрлэн сумын 5 дугаар багт 15/ нийлүүлнэ.

**3.Ерөнхий шаардлага:**

3.1.Хүлэмж нь нийлэг хальсан бүрхүүлтэй, нуман оройтой, хавар-зун-намар ашиглагдах, төрөл бүрийн хүнсний ногоо, цэцэг, эмийн ургамал, мод үржүүлгийн ажил хийх боломжтой.

3.2.Хүлэмжийн иж бүрдэл нь MNS 6636:2016 стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

3.3.Нийлүүлэх хүлэмж нь импортын материал сонгон худалдан авч буй тохиолдолд тохирлын гэрчилгээ, тухайн улсын стандартад нийцсэн сертифткат, паспортыг хавсаргана.

3.4.Тухайн хүлэмжийг барих зураг, тайлбартай байна.

3.5.Ажлыг гүйцэтгэгч байгууллага мэргэжлийн багшаар тухайн хүлэмжийг барих, ашиглах, хүнсний ногоо тарих чиглэлээр ашиглагч байгууллагын ногоочид, иргэдэд технологийн сургалтыг зохион байгуулна.

3.6.ХАА-н тоног төхөөрөмж, хүлэмж импортлох чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан мэргэжлийн аж ахуй нэгж, байгууллага, төрийн бус байгууллага байна.

4. Нийлүүлэх хүлэмжийн материал нь доорх техникийн шаардлага хангасан байна. Үүнд:

| № | Материалын нэр | Техникийн шаардлага |
|---|---|---|
| 1 | **Нийлэг хальсан бүрхүүл** | ➢ Нарны гэрэл сайн нэвтрүүлдэг, тунгалаг, дулаан барих чадвартай, усан дусал үүсэхгүй байх,<br>➢ -40-өөс +50 хэмд физик шинж чанараа алддаггүй, 0.10 мм-ээс дээш зузаантай, ашиглалтын хугацаа 2-оос доошгүй жил ашиглах боломжтой.<br>➢ Заагдсан хэмжээтэй нуман нурууг бүрэн хучихад хүрэлцэхүйц хэмжээтэй байна. |

345
2020.02.03.

| | | |
|---|---|---|
| 2 | **Нуман нуруу /карказ/** | ➢ Хүлэмжийн өргөн 4 м, урт 8 м, өндөр нь 2.5 м-аас доошгүй байх ба нийт талбай 32 м$^2$ байна<br>➢ Зэвэрдэггүй цайрдсан гангаар хийсэн их биетэй, 1.5 мм буюу түүнээс дээш зузаан ханатай, диаметр нь 25 мм буюу түүнээс дээш, босоо нуман тулгууруудын хоорондох зай 0.8 метрээс ихгүй, 25 см зузаантай, 25м/сек-ийн хурдтай салхийг тэсвэрлэх чадвартай байх<br>➢ Хучлага болон бусад хийгдсэн материал тохөөрөмжийг даахуйц бат бэх, бүрэн бэхэлгээтэй, даац нь 15г/м² байх |
| 3 | **Усалгааны төхөөрөмж** | ➢ **Усалгааны хоолой:** Ил болон далд хөрсний дуслын усалгааны иж бүрдэл төхөөрөмж, 32 м$^2$ буюу 8м-ийн урт, 4 м-ийн өргөнтэй талбайг услах хүчин чадалтай байх, |
| 4 | **Агууржуулагч** (гараар: аар) | ➢ **Агааржуулагч:** Агааржуулах зориулалтын хийцтэй, түүнийг нээж, хаадаг нээлхийтэй байх, |
| 5 | **Хаалга** | ➢ Хаалганы өргөн 0,9-1,0 м, өндөр 1,9 м-ээс доошгүй байх,<br>➢ Хаалгыг 1,5 мм зузаантай цайрдсан 25*25 мм дөрвөлжин огтлолтой, 25 мм-ийн ган хоолойгоор хийнэ.<br>➢ Хэрэв нээлхий хийгээгүй тохиолдолд хүлэмжийн 2 талд хаалга хийх, |
| 6 | **Дагалдах багаж, сэлбэг** | ➢ Үйлдвэрлэгчийн стандартын дагуу дагалдах сэлбэг, хүлэмж угсрахад зайлшгүй шаардагдах багаж, даруулга, гадас, температур, агаарын харьцангуй чийг хэмжигчтэй байна. |

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Х.БАТ-ЭРДЭНЭ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ч.БОЛОРМАА

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.АЛИМАА

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА Ч.САМБУУБААТАР